



ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
 ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГА
 Д.НЯМХҮҮ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
 ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
 АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
 Бага тойруу, Засгийн газрын IV байр,
 Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013-04-08 № 2/47
 1/47

Авлага барагдуулах тухай

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2012 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын мэргэжлийн хяналтын газраас 2007 онд тус төвийн захирлаар ажиллаж байсан Ц.Оюунчимэг, Тандалт судалгаа эрхэлсэн дэд захирал Ц.Энхбаяр нартай холбогдуулан тавьсан актын үлдэгдэл 79,292.9 мянган төгрөгөөс тайлант хугацаанд 132.0 мянган төгрөг хураан барагдуулж, үлдэх 79,160.9 мянган төгрөгийг Баян зүрх дүүргийн шүүхэд нэхэмжлэх гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх ...” гэсэн заалтыг зөрчсөн байна.

“Төрийн аудитын тухай” хуулийн 15-дугаар зүйлийн 1-ийн 12 дугаар заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1 дүгээр заалтыг үндэслэн шаардах нь:

Дээр дурдсан асуудлыг шийдвэрлэн авлагыг барагдуулж, 2013 оны 10 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт хариу ирүүлэхийг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дарга Д.Нямхүү, ерөнхий ня-бо Д.Алтанхуяг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
 АУДИТОР

ПАНТЕР МИДЛАНД АУДИТ ХХК-ИЙН
 ЗАХИРАЛ

ЗӨВШӨӨРСӨН:

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
 ТӨВИЙН ДАРГА

Д.УРТНАСАН

Б.БЯМБАСҮРЭН

Д.НЯМХҮҮ

